

ЭРДЭМТНИЙ ОЙ

М. С. КАПИЦАГИЙН 60 НАСНЫ ОЙД

Энэ 1981 оны арван нэгдүгээр сарын 5-нд Зөвлөлтийн нэрт хятад судлаач, олон улсын харилцааны томоохон мэргэжилтэн түүхийн ухааны доктор, профессор Михаил Степанович Капицагийн нас сүүдэр 60 хүрч байна. Тэрээр Украины Хмельницкийн мужийн Юрковцы гацаанд ядуу тариачны гэрт төржээ. М. С. Капица 1941 онд Москвагийн гадаад хэлний улсын дээд сургууль, 1948 онд ЗСБНХУ-ын ГЯЯ-ны Дипломатын дээд сургуулийг сурч төгсөхдөө хятад болон англи хэлийг сайн эзэмшиж, онолын өндөр мэдлэгтэй болжээ. Аугаа их эх орны дайн ид явагдаж байсан 1943 онд Зөвлөлт улс 22 настай залуу дипломатыг Чүнцин дахь Элчин Сайдын Яаманд хариуцлагатай ажилд томилжээ. Хятадад байх үедээ нүдээр үзэж гар бие оролцсон түүхэн чухал үйл явдлууд нь Капицагийн сэтгэлд арилшгүй ул мөр үлдээгээд зогсоогүй түүнийг хятадын ард түмний тэмцлийн түүхийг өргөн хүрээгээр харж хятадын хувьсгалын хэтийн төлөвийг үнэлэх оролдлого хийхэд хүргэжээ.

БНХАУ тунхаглагдсаны дараахан 1950 оны арван нэгдүгээр сард Капица Бээжинд дахин томилогдон ирж Хятадад үзүүлэх Зөвлөлтийн тусламжийн өргөн программыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцжээ. Чухам энэ үед Капица Зөвлөлт-хятадын харилцааны түүхийг судалгааны ажлынхаа сэдэв болгон сонгон авчээ. Энэ нь хятадын шинэхэн үеийн түүх, Алс Дорнод дахь олон улсын харилцааны түүхийн судлал дахь хамгийн хариуцлагатай маш бага судлагдсан нарийн сэдэв байсан боловч 1953 оны 4-р сард Москвад буцаж ирснийхээ дараахан Капица энэ сэдвээр эрдмийн зэрэг амжилттай хамгаалжээ. 1958 онд М. С. Капица Октябрийн социалист их хувьсгалаас 1958 он хуртлэх үеийг хамарсан Зөвлөлт-хятадын харилцааны түүхээр нэгэн сэдэвт зохиол хэвлүүлж, мөн онд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Тэр цагаас хойш М. С. Капица нэгэн сэдэвт зургаан зохиол бичсэнээс гадна А. А. Громыко, Б.Н Пономарев нарын редакторласан «ЗСБНХУ-ын гадаад бодлогын түүх» (М., 1976), «Дэлхийн хоёрдугаар дайнаас хойших олон улсын харилцаа» (М., 1962), «Олон улсын харилцаа ба ЗСБНХУ-ын гадаад бодлого» (М., 1963), «Дайны дараахи

жилүүдийн Алс Дорнод дахь олон улсын харилцаа» (М., 1977), «Алс Дорнод дахь олон улсын-харилцааны түүх» (1945-1977» (Хабаровск 1978) зэрэг хамгийн том II бүтээлийг зохиоход оролцжээ.

М. С. Капицагийн бүтээлүүд шинжлэх ухааны том асуудлуудыг шийдвэрлэхэд шаардагддаг чин эрмэлзэл, түүхийн материалыг хамарсан өргөн хүрээ жинхэнэ эх сурвалжийн бүтээлч ашиглалт, зөвлөлтийн түүхийн ухааны байр суурийг хэлбэрэлтгүй хамгаалсан байдал, хөрөнгөтний болон маоист түүх бичлэгийн мушгин гуйвуулалтад өгсөн шийдвэртэй няцаалт зэргээрээ тод ялгардаг юм.

М. С. Капицагийн Алс Дорнод дахь дайны дараахи жилүүдийн олон улсын харилцааны түүхийн судалгаа нь онцгой анхаарал татдаг юм. Түүний бүтээлүүд нь академич А. Л. Нарочницкий, Е. М. Жуков нарын тууривсан нэрд гарсан зохиолуудын үргэлжлэл болсон юм. «Алс Дорнод дахь олон улсын харилцааны түүх 1945-1977» нэг сэдэвт зохиол нь түүний энэ салбар дахь судалгаа шинжилгээний гол үр дүн болсон бөгөөд М. С. Капица энэ номонд тус бүс нутгийн олон улсын харилцааны системд Хятад болон БНМАУ-ын эзэлж буй үүрэг, байр суурийг хөндсөн хэсгүүдийг бичжээ.

БНХАУ-ын гадаад бодлогын чиг шугамын судалгаа нь. М. С. Капицагийн шинжилгээний ажлын нөгөө нэг чиглэл болдог юм. Түүний «БНХАУ: гурван арван жил ба гурван өөр бодлого» (М., 1979) гэдэг нэгэн сэдэвт зохиол нь уншигчдын сонирхлыг онцгой татжээ. М.С. Капица энэ бүтээлдээ хятадын маоист эрх баригчдын гадаад бодлогын чиг шугам болон түүний дотоод бодлогын нягт уялдааг тод томруун харуулжээ. Чухамхүү БНХАУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн «асуудлууд милитаричлах бодлогын эдийн засагт нөлөөлж буй хор уршиг тасралтгүй үргэлжилж буй дотоод улс төрийн тэмцэл нь олон улсын түгшүүртэй байдлыг хурцатгах зөвлөлтийн эсрэг үзлийг дэвэргэх, империалист ард түмний заналт дайсан империализмтэй сүлбэлдэхэд хүргэж буй үндсэн шалтгаан гэдгийг харуулжээ. М. С. Капица байнга өөрчлөгдөж байдаг улс төрийн уриа заалтуудыг задлан шин-

жилсний үндсэн дээр Хятадын гадаад бодлогын жижиг хөрөнгөтний, социализмын эсрэг шинж чанар нь хэзээд хэвээр байдаг гэсэн дүгнэлтэд хурчээ. Мөн хятадыг милитарист хэт их гүрэн болгох бодлогын жанжлагч зорилго нь хэвээр үлдсээр буйг М. С. Капица заагаад, Ази тив Бээжингийн түрэмгий бодлогын тэргүүн бай болдгийг нотлоод энэ бодлого нь Хятадын Ази дахь хөрш орнуудад хичнээн их аюултайг үнэмшилтэй харуулжээ.

Энэ бүх жилүүдэд Михаил Степанович дипломатын хувьд их үр бүтээлтэй ажиллаж иржээ. 1954-1960 онд тэрээр ГЯЯ-ны төв аппаратад хариуцлагатай ажил хийж байгаад 1960 онд ЗСБНХУ-аас Пакистанд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайдын тушаалд томилогджээ. Вьетнамын эсрэг америкийн түрэмгийллийн үед М. С. Капица ГЯЯ-ны Зүүн Өмнөд Азийн хэлтсийг удирдаж байсан бөгөөд 1970 онд ГЯЯ-ны Алс Дорнодын нэгдүгээр хэлтсийн дарга болжээ. М. С. Капица ЗСБНХУ-ын ГЯЯ-ны коллегийн гишүүн юм. Хятад болон Алс Дорнодын асуудлаархи Зөвлөлтийн том мэргэжилтний хувьд М.С. Капица Солонгос ба Энэтхэг-хятадын хойгийн асуудлаархи Женевийн бага хурал (1954), Вьетнамын асуудлаархи Парижын зөвлөлгөөн (1973) зэрэг олон олон улсын олон чухал хуралд оролцож иржээ. 1979 онд М. С. Капица БНХАУ-тай ЗХУ-ын хийсэн хэлэлцээнд Зөвлөлтийн засгийн газрын төлөөлөгчдийн тэргүүний орлогчийн үүрэг гүйцэтгэж байв. Зөвлөлт засгийн газар түүний олон талт үр бүтээлт үйл ажиллагааг үнэлж Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 2 удаа, ЗСБНХУ-ын медалиудаар шагнажээ

М. С. Капица залуу боловсон хүчнийг бэлтгэх ажилд их хүч чармайлт гаргадаг юм. Тэрээр 1952-1960 онд Москвагийн олон улсын харилцааны дээд сургуульд багшилж, 1954 онд доцент, 1960 онд профессор цол

хүртжээ. 1962 оноос тэрээр Москвагийн Улсын Их Сургуулийн Ази, Африкийн дээд сургуулийн Дорно дахины орны эдийн засгийн кафедрьг удирдаж иржээ.

М. С. Капица өргөн олон сонсогчидтой байнга уулзаж, холбоотой байдаг юм. Зөвхөн дотооддоо төдийгүй БНАГУ, БНСЧСУ, БНПАУ, БНУАУ, БНБАУ, БНМАУ-ын өргөн олон нийтийн өмнө түүний дайчин хурц үгнүүд цууриатдаг юм.

Нэрт Дорно дахинч М. С. Капица Монголын шинэхэн үеийн судлалд оруулсан үнэт хувь нэмрээрээ манай уншигчдын хэзээний танил юм. Түүний Монгол-зөвлөлтийн найрамдлын сэдвээр «Тэмцлээр гагнагдсан нөхөрлөл» («Дружба завоеванная в борьбе» М.. 1965), ном монгол хэлэнд орчуулагдаж бүр 1966 онд хэвлэгджээ. М. С. Капицагийн Монгол-зөвлөлтийн ард түмний найрамдлыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг өндөр үнэлж түүнийг БНМАУ-ын засгийн газар 1971 онд «Алтан гадас» одонгоор, 1979 онд «Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн» одонгоор, мөн «Найрамдал» болон бусад медалиудаар шагнажээ.

Михаил Степанович Капица бүтээлч хүч хөдөлмөрийнхөө их цэцэглэлтийн үед яваа бөгөөд түүний дипломат ба эрдэмтний хувьд хийж буй үйл ажиллагаа нь ЗХУ-ын коммунист бүтээн байгуулалт, даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, ЗХУ ба БНХАУ-ын харилцааг сайжруулах үйл хэрэгт зориулагдаж байна. БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн нийгмийн ухааны хүрээлэнгүүд, түүний дотор Дорно дахины Судлалын Хүрээлэнгийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнууд Михаил Степановичид эрүүл энх, сайн сайхныг хүсэн, олон талт үр бүтээлч үйл ажиллагаандаа улам их амжилт гаргахыг түүнд ерөөж байна.